



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 01

Номгон

Г Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, г
зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан
сэргийлэх тухай

Баянхонгор аймагт 2020 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 44 гэмт хэрэг бүртгэгдэж 27 нэгжээр буюу 1.5 дахин өссөнтэй холбогдуулан энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6.а, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1.Төсөвт байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт

1.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон түүнийг дагаж гарсан журмууд, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны А/71 дүгээр тогтоолоор батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

1.2.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн албан хаагч, хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хуулийн дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, мэдээлэх, холбон зуулчлах ажлыг зохион байгуулах;

1.3.Албан хаагч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх магадалалтай, өртөх эрсдэлтэй болон өртсөн бол шалтгаан нөхцөлийг тогтоох, гэр бүлийн гишүүдтэй ганцаарчлан уулзах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүчирхийлэл үйлдэгчээс дахин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхгүй байх талаар баталгаа гаргуулах, энэ чиглэлээр үр дүнтэй нөлөөллийн арга хэмжээ авч ажиллах;

1.4.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар албан үүрэгтэйгээ холбоотойгоор олж мэдсэн бол цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн Засаг даргад мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх;

2.Сум, багийн Засаг дарга нарт

2.1.Сум, багийн нутаг дэвсгэрт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд сургалт, мэдээлэл өгөх, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

2.2.Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, холбогдох хуулинд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

2.3.Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

2.4.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа иргэн, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;

2.5.Сум, багийн Засаг дарга нар хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийг дуудан ирүүлж, шаардлага тавих, сануулга өгөх, хохирогчийг эмнэлгийн яаралтай тусламжид холбох, хохирогчийн байгаа орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, эсхүл хохирогчийг төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх арга хэмжээ авч ажиллах;

3.Аймгийн Цагдаагийн газарт

3.1.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн аян, арга хэмжээ зохион байгуулж, иргэдэд сургалт сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулах;

3.2.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулах;

3.3.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил үйлдэж баривчлагдсан этгээдүүдийг оршин суугаа газрын хамтарсан багт тухай бүр холбон зуучлах, хяналт тавих;

3.4.Гэр бүлийн хүчирхийллийн улмаас удаа дараа баривчлагдаж буй этгээдүүдэд онцгойлон анхаарч, хяналтанд авах ажлыг зохион байгуулах;

3.5.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болон гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, аюулын зэргийн үнэлгээ хийж, түүнийг үндэслэн хохирогчийг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв

болон эмнэлэгт хүргэх, эсхүл төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх ажлыг зохион байгуулах;

3.6. Шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн хүн, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ авч ажиллах;

3.7. Хүүхэд өөрийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүчирхийлэлд өртсөн бол тэдгээрийн саналыг үл харгалзан хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах;

3.8. Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид орчинг дэмжих нь хөтөлбөрийн чанарыг сайжруулж, хэрэгжүүлэх;

4. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт /Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбар нэг цэгийн үйлчилгээний төв/

4.1. Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох мэргэжлийн байгууллагатай солилцох арга хэмжээ авч ажиллах;

4.2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай насанд хүрээгүй хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй иргэн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих, ажлыг зохион байгуулах;

4.3. Аймгийн хэмжээнд хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх тусгай дугаарын үйлчилгээг нэвтрүүлэх, 108 утсыг сурталчлах ажлыг зохион байгуулах;

4.4. Гэр бүлийн боловсролыг нас хүйс, амьдарлын мөчлөгт тохируулан системтэй олгох;

4.5. Нэг цэгийн үйлчилгээ болон түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлсэн иргэдийн талаарх мэдээллийг тухай бүр Цагдаагийн газарт мэдээлэх;

4.6. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нарт аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн арга зүйгээр хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

4.7. Иргэд олон нийтэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;

4.8. Гэр бүлийн хүчирхийллийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдыг чадавхжуулах сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

4.9. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс үзүүлэх;

5.Эрүүл мэндийн газарт

5.1.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах, хохирогчийг шаардлагатай үйлчилгээний талаарх мэдээллээр хангах, хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

5.2.Хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах ажлыг тухай бүр зохион байгуулах;

5.3.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар албан үүрэгтэйгээ холбоотойгоор олж мэдсэн бол цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн Засаг даргад заавал мэдээлэх;

6.Сум, багийн хамтарсан багт

6.1.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;

6.2.Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагад холбон зуучлах ажлыг зохион байгуулах;

6.3.Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хамаарал бүхий этгээдүүдэд хийсэн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

6.4.Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

6.5.Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.6.Гэр бүлийн хүчирхийллийн улмаас баривчлагдсан, гэмт хэрэгт холбогдон шалгагдсан иргэдэд тухай бүр хяналт тавьж, тэдэнд болон гэр бүлд нь чиглэсэн шаардлагатай үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах;


6.7.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хохирогчийг мэдээллээр хангах, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлж, үнэлгээнд үндэслэн хохирогчийн хэрэгцээг тодорхойлж, хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

6.8.Хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлэх судалгаа хийж, бүртгэл хөтлөх, үйл ажиллагаандаа ашиглах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах

6.9.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх чиглэлээр хамтарсан багтай хамтран ажиллах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, туслалцаа, дэмжлэгийн талаар эцэг, эх, багш, холбогдох бусад ажилтанд зөвлөгөө өгөх, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагч, багш, боловсролын байгууллагын бусад ажилтан, эцэг, эхэд мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах;

7.Энэхүү албан даалгаврын холбогдох заалт бүрийг хяналтандаа авч, хэрэгжилтийг зохион байгуулан үр дүнг улирал бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст ирүүлэхийг сум, багийн Засаг дарга, байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

8.Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, үр дүнг тооцож хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Энхбаяр/-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН